

БАТЛАВ.
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

БАТЛАВ.
ГАДААД ХАРИЛЦААНЫ
САЙД

Б.БАТЦЭЦЭГ

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

О.АЛТАНГЭРЭЛ

**“МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР ХООРОНДЫН МОНГОЛ УЛСЫН УЛААНБААТАР ХОТЫН ДУЛААНЫ
ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦЫН ӨРГӨТГӨЛ, ШИНЭЧЛЭЛИЙН
ТӨСЛИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл

1.1 Хууль эрх зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2021 оны “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 2.1-т “Эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам сүлжээг шинээр барьж байгуулан хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлнэ.” гэж, мөн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.4-т “Дулааны гуравдугаар цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн 300 МВт-ын хүчин чадалтай шинэ эх үүсвэр барих” гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.2.6-д “Дулааны хоёрдугаар цахилгаан станц, Дулааны гуравдугаар цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн станцуудын хүчин чадлыг өргөтгөх төслийг хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан.

Мөн “Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох зорилтын хүрээнд 4.2.34-т “Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг хангах дулааны цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгөж, шинэ цахилгаан станц барьж дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортолно.”, Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 3.7.17-д “Улаанбаатар хотын дулааны цахилгаан станцуудыг шинэчлэн, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.” гэж заасан.

Эрчим хүчний салбар нь улсын хэмжээнд эдийн засгийн тэргүүлэх ач холбогдолтой томоохон бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, бүс нутгуудад үйлдвэрлэл технологийн паркууд байгуулах, жижиг дунд үйлдвэрүүдийг хөгжүүлж ажлын байр бий болгох цаашлаад хот, суурин газруудын

шинэ суурьшлын бүсүүдийг бий болгох, салбарыг хөгжүүлэх тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн.

Дээрх бодлогын баримт бичгийн хүрээнд 2024 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр гарын үсэг зурсан “Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.3-т заасны дагуу Улсын Их Хурлаар соёрхон батлуулах шаардлагатай байна.

1.2 Практик шаардлага

Эрчим хүчний салбар сүүлийн жилүүдэд өвлийн их ачаалалд системийн нийт суурилагдсан хүчин чадлыг бүрэн ашиглаж, нөөц тоноглолгүй, импортын эрчим хүчний дэмжлэгтэйгээр өвлийг давж байна. Тодруулбал, 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр системийн оргил ачаалал 1636 МВт хүрч, 71 МВт-ийг хязгаарласан бөгөөд цаашид эрчим хүчний хэрэглээ өсөн нэмэгдэхийн хэрээр хэрэглэгчдийг эрчим хүчээр хангахад хүндрэлтэй нөхцөл байдал үүсч байна.

Цахилгаан эрчим хүчний хэрэглээ сүүлийн жилүүдэд дунджаар 8-10 хувиар өсөж байна. Энэ хэрэглээний өсөлтийг хангах, дотоодын эрчим хүчний эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэх, нөөц чадлын зохистой хэмжээнд буюу 20 хувь илүү хүргэх шаардлагатай байна.

Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системд жилд дунджаар 380 Гкал/ц ачаалалтай 500 техникийн нөхцөл олгогдож, 180 Гкал/ц ачаалалтай 450 орчим барилга, байгууламж шинээр холбогдож байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд гадна агаарын температур олон жилийн дунджаас доогуур байсан нь өвлийг харьцангуй хүндрэл багатай давахад нөлөөлсөн. Гэвч агаарын температур -39⁰ градусаас дээш тогтвортой хүйтэрвэл дулаан хангамжийн систем чадлын дутагдалд орж дулаан дамжуулах сүлжээний алслагдсан цэгүүдэд хөлдөлт үүсэх эрсдэлтэй нөхцөлд байна.

Сүүлийн 3 жилийн хугацаанд цар тахал, эдийн засгийн өсөлт саарсан, эрчим хүчний үнэ тарифт өөрчлөлт оруулах боломжгүй байсан зэргээс шалтгаалан 2019 онд эрчим хүчний салбар 59.3 тэрбум төгрөг, 2020 онд 88,1 тэрбум төгрөгийн, 2021 онд 77.8 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж, 2022 онд 187.4 тэрбум, 2023 онд 98 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны алдагдалтай ажилласан.

Хэрэглэгчдийн цахилгаан, дулааны тариф бодит өртгөөс доогуур тогтоогдож байгаа нь эрчим хүчний компаниудад нүүрс нийлүүлэгч уурхайнууд, бэлтгэн нийлүүлэгчид, банк санхүүгийн байгууллагуудад төлөх зээл, зээлийн хүүгийн төлбөр нэмэгдэж байна. Түүнчлэн дулааны цахилгаан станц, цахилгаан, дулаан дамжуулах түгээх, хангах компаниуд хөрөнгийн дутагдлаас шалтгаалж техникийн засвар, үйлчилгээг цаг тухайд нь бүрэн хийж чадахгүй байгаа нь насжилт өндөртэй,

хуучин тоноглол бүхий үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд гэнэтийн аваар, саатал гарах эрсдэлийг нэмэгдүүлж, хэрэглэгчдийг эрчим хүчээр тасралтгүй, найдвартай хангахад хүндрэл үүсгэж байна.

Дээрх нөхцөл байдлуудаас шалтгаалан эрчим хүчний салбарт өглөг, авлага хуримтлагдаж, хөрөнгө оруулалтын төслүүдийг өөрөө санхүүжүүлэх мөнгөн хөрөнгө бүрдэх боломжгүй байна.

Эрчим хүчний салбар системийн суурилагдсан хүчин чадлын цар хүрээг нэмэгдүүлэх, найдвартай тогтвортой үйл ажиллагааг хангах, нөөц чадлыг зохистой хэмжээнд хүргэх, хүчин чадал нэмэгдсэнээр сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг нэмж холбох боломжтой болгох зорилгоор шинээр том чадлын нүүрсээр ажиллах Тавантолгой 450 МВт, Баянгийн 660 МВт, Багануур 400 МВт, Бөөрөлжүүт 300 МВт, Дулааны гуравдугаар цахилгаан станц 300 МВт, Дулааны хоёрдугаар цахилгаан станц 300 МВт-ын дулааны цахилгаан станцуудыг барьж байгуулахаар ажиллаж байна.

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 24, 25 дугаар хуралдааны протоколыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 15 дугаар тэмдэглэлийн дагуу Дулааны гуравдугаар цахилгаан станцыг нийт 300 МВт (50+250 МВт)-аар үе шаттай өргөтгөн, шинэчлэх төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Оросын Холбооны Улсын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллалаа.

Хамтын ажиллагааны хүрээнд төслийн нийт төсөвт өртөг, барилга угсралтын ажлын хугацааг нарийвчлан тодорхойлохын тулд “Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг талууд эцэслэн тохиролцсон.

Энэхүү хэлэлцээрийн төсөл нь нийт 11 зүйлтэй бөгөөд тус хэлэлцээрт Дулааны гуравдугаар цахилгаан станцын өндөр даралтын хэсгийг 50 МВт-ын (1х50 МВт) блок станцаар өргөтгөх, дунд даралтын хэсгийн 48 МВт-ын (4х12 МВт) блок станцыг буулгаж суурин дээр нь 250 МВт-ын (2х125 МВт) блок станц шинээр барих төслийн зураг төсөл боловсруулах, инженерийн судалгаа, шинжилгээ явуулах ажлын цар хүрээ, ерөнхий нөхцөлийг тодорхойлж, захиалагчаар “Дулааны гуравдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компани, гүйцэтгэгчээр Оросын Холбооны Улсын талаас санал болгосон “Интер РАО Экспорт” компанийг томилох асуудлыг тус тус зохицуулахаар тусгасан.

Иймд 2024 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр гарын үсэг зурсан “Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон

батлаж, хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох хэрэгцээ, шаардлага үүсээд байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

“Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай зүйлтэй байна.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал

Хэлэлцээрийн төсөл соёрхон батлагдсанаар эхний ээлжинд зураг төсөл боловсруулах ажлыг Оросын Холбооны Улсын талаас санал болгож, эрх олгосон компаниар гүйцэтгүүлэх эрх зүйн зохицуулалт бий болно. Ингэснээр Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн нийт төсөвт өртөг барилга угсралтын хугацааг нарийвчлан тодорхойлж харилцан зөвшилцсөнөөр цаашид барилга угсралтын ажил, Оросын Холбооны Улсаас экспортын зээл авах асуудлаар хэлцэл хийх нөхцөл боломж бүрдэнэ.

Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн эх үүсвэрүүдийн суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэн Хан-уул дүүрэг, Баянзүрх дүүргийн хэрэглэгчдийг шинээр дулаан, цахилгааны эрчим хүчээр найдвартай хангах нөхцөл бүрдэнэ.

Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамж системүүдийн эх үүсвэрүүдийн суурилагдсан хүчин чадал 2418 Гкал/ц, нийт холбогдсон хэрэглэгчдийн дулааны тооцоот ачаалал 3373.7 Гкал/ц-т хүрч 955.7 Гкал/ц-ийн дулааны эрчим хүчний дутагдалтай байна. Ойрын хугацаанд Дулааны хоёрдугаар цахилгаан станц, Дулааны гуравдугаар цахилгаан станц, Дулааны дөрөвдүгээр цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн ажлуудыг үе шаттай хийхээр төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд 2030 оноос дотоодын эрчим хүчний эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадал 2 дахин нэмэгдэж 3000 МВт-д хүрч, эрчим хүчний салбар эдийн засгийг дэмжигч салбар болно.

Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд 2024-2028 онд том хүчин чадлын цахилгаан станцуудыг /Бөөрөлжүүтийн 300+300 МВт, Баянгийн 600 МВт, Тавантолгой 300 МВт, Сүхбаатарын 70 МВт/ ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Эдгээр эх үүсвэрүүдийг ашиглалтад орох хүртэл импортын эрчим хүчийг боломжит дээд хэмжээнд хүртэл ашиглана.

Системийн суурь горимд ажиллах тогтвортой үйл ажиллагаатай том чадлын станцууд ашиглалтад орсноор нар салхины сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг холбох техникийн боломж бүрдэж, эх үүсвэрийн бүтэц оновчтой болно.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, бусад хуульд нийцүүлэн боловсруулсан бөгөөд хуулийн төсөлтэй уялдуулан шинээр боловсруулах хууль тогтоомжийн төсөл байхгүй болно.

---oOo---